БАТЛАВ.
БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Д.ДЭЛГЭРМАА

20 19 оны 02 дугаар сарын 19

“ЗАМЫН ЦАГДААГИЙН ХЭЛТСИЙН БАРИЛГА” /УЛААНБААТАР, БАЯНГОЛ ДҮҮРЭГ/ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1	Байршил	Баянгол дүүрэг 20 дугаар хороо, Замын цагдаагийн хэлтэс
2	Ажлын цар хэмжээ	Баянгол дүүргийн замын цагдаагийн хэлтсийн барилга тэнхлэгээрээ 15.0м х 20.0м хэмжээтэй, зоорьтой 3 давхар, **Ажлын тоо хэмжээ** гэсэн бүлэгт байгаа ажлуудыг хийж гүйцэтгэнэ.
3	Барилга, тохижилтын ажлын зохион байгуулалт, түүнд тавигдах шаардлагууд	1. Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол Улсад мөрдөж буй хууль, тогтоомж, БНбД, стандарт, холбогдох журам зааврын дагуу хийж гүйцэтгэнэ. 2. Талбайн ажлыг хийж гүйцэтгэхдээ бусад ажилтай уялдуулан, тухайн байршилд ажил үйлчилгээ явуулж буй аж ахуй нэгж байгууллагуудын ажил үйлчилгээнд ямар нэгэн саад бэрхшээл гаргалгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэн талбайн зохион байгуулалтыг хийж ажиллах. 3. Ажлыг гүйцэтгэж байх явцад технологийн үе шат бүрд гүйцэтгэсэн ажлыг захиалагчийн хяналтын инженерт үзүүлж байх ба техникийн шаардлага хангасан гэж үзвэл холбогдох газруудад туршилтуудыг хийлгэх зөвшөөрлийг авч ил, далд ажлын акт, гүйцэтгэлийн зураг үйлдсэнээр дараагийн үе шатны ажлыг гүйцэтгүүлэх байдлаар ажлыг гүйцэтгэж эхлэх үеэс нь эхлэн ажлыг хийж дуусгах хүртэлх бүх технологийн үйл ажиллагаанд хяналт тавина. 4. Ажил гүйцэтгэх явцад талбайд ажиллаж буй ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч ажиллана.
4	Захиалагчийн хяналтын ажил	1. Ажлын явцад гарах зураг төсөвтэй холбоотой асуудлыг газар дээр нь холбогдох хүмүүстэй хамтарч шийдвэрлүүлнэ.

2. Гүйцэтгэгч байгууллага нь заагдсан ажлын тоо хэмжээ, зургийн чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэн ажиллана.

3. Талбайд барилга, тохижилтын ажлын журналыг байнга бэлэн байлгаж, холбогдох хяналтын инженерүүдийн өгсөн шаардлага, дүгнэлтийг журналд бичиж хөтлөн захиалагчаар баталгаажуулна.

4. Барилга угсралтын ажлыг гүйцэтгэж эхлэх үеэс нь эхлэн ажлыг хийж дуусгах хүртлэх бүх технологийн үйл ажиллагаанд хяналт тавина.

5. Материалын чанарт хяналт тавина.

6. Магадлашгүй ажлын зардалд зориулсан мөнгөн дүнг төслийн менежерийн шийдвэрийн дагуу захиалагч, гүйцэтгэгч, ашиглагчийн төлөөлөгчид оролцсон комисс акт тогтоон төсөв тооцоо хийж, /шаардлагатай бол зураг хийх/ баталгаажуулж санхүүжүүлэх болно.

5 Гүйцэтгэгч байгууллага

1. Үйлдвэрлэлийн технологийн үйл ажиллагаа, зохион байгуулалтын төлөвлөлтийг боловсруулж тендерт ирүүлнэ.

2. Ажил гүйцэтгэх явцдаа байнга фото зургаар баталгаажуулан далд ажлын акт үйлдэнэ.

3. Ажлын явцад өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас эвдэрсэн байгууламжуудыг нөхөн сэргээн засварлаж хэвийн байдалд оруулна.

4. Ажил гүйцэтгэх явцад талбайд ажиллаж буй ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч, аюулгүй ажиллагааны нөхцөлийг бүрдүүлж хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээр бүрэн хангаж ажиллана.

5. Байгалийн гэнэтийн гамшиг, гал түймэр, үер усны гамшигаас сэргийлэн даатгалд бүрэн хамрагдсан аюулгүй байдлыг хангаж ажиллана.

6. Эдгээр арга хэмжээг аваагүйгээс гэнэтийн гамшигт өртөх, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зөрчил гарвал хохиролыг гүйцэтгэгч бүрэн хариуцна.

7. Талбайд барилгын ажлын журналыг байнга бэлэн байлгаж, холбогдох хяналтын инженерүүдийн өгсөн

		шаардлага, дүгнэлтийг журналд бичиж хөтлөн захиалагчаар баталгаажуулна.
6	Угсралт суурилуулалтын ажил	1. Баянгол замын цагдаагийн хэлтсийн барилгын ажлыг хийж гүйцэтгэхдээ галын болон техникийн аюулгүй байдлыг хангасан байна. 2. Уг ажлыг гүйцэтгэхдээ Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, журам, норм дүрмүүдийг баримтлан ажиллана.
7	Ажлын тоо хэмжээ	1. Ажлын тоо хэмжээг үнэлэхдээ ажлын тоо хэмжээний жагсаалт болон тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа, гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт зэргийг бодит байдалтай холбон нягтлан үзэхийг анхааруулж байна.
8	Ажлын тоо хэмжээг үнэлэх санамж	1. Гэрээнд тусгайлан заагаагүй нөхцөлд тендерт ирүүлсэн үнийн саналд ажлын тоо хэмжээнд тохирсон үнэд ажлыг явуулахад шаардагдах тоног төхөөрөмж, ажиллах хүчний хөлс материал, түүний элэгдэл засвар, нийгмийн ба эрүүл мэнд, үйлдвэрлэл нийлүүлэлтийн ба ахуйн зориулалттай бүх зардлууд мөн нэмэгдэл дайвар захиалагчийн техник хяналтын зардал, гэрээний үүрэгт хамруулах ёстой бусад үүрэг хариуцлагыг тооцож шингээсэн байна. 2. Ажлын тоо хэмжээг үнэлэхдээ барилгын төсөв зохиох дүрэм БНбД 81-95-12-ын шинэчилсэн программын дагуу үнэлж, үнэлгээнд техник хяналт, магадлашгүй ажил, НӨАТ, зураг төсвийн үнэ 9,866,160 /Есөн сая найман зуун жаран зургаан мянга нэг зуун жар/ төгрөг, нормчлолын санг тооцож оруулна. Ажлын тоо хэмжээнд заагдсан ажлыг үнэлэхдээ ажил гүйцэтгэх технологийн дагуу ажил, ажилбаруудаар задалж нэгжийн норм үнэлгээгээр үнэлэхийг анхааруулж байна. Гэхдээ нэгжийн норм үнэлгээ дотроо тусгагдсан ажилбаруудыг дахин давтан үнэлсэн байж болохгүй.
9	Хүлээлгэн өгөх	1. Барилгын ажлын үед захиалагчийн талын холбогдох мэргэжлийн хүмүүсийг байлцуулан хяналтыг ажлын үе шат бүрт хийлгэж акт бүрдүүлнэ. Энэ талаар захиалагчид урьдчилан мэдэгдэнэ. Ажил дууссаны дараа гарсан хог хаягдлыг бүрэн цэвэрлэж ажил хүлээн авах комисст хүлээлгэн өгнө. Барилгын ажлын баталгаат хугацаа 3 жил байна.
10	Шинэ материалын баталгаат хугацаа 10	1. Барилгын ажлын зураг төсөл, норм, дүрэм, технологийн шаардлагыг зөрчсөн нөхцөлд захиалагч байгууллагын эрх бүхий төлөөлөгчид, орон нутгийн

жилээс байна.	багагүй	мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчид барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.

ХЯНАСАН:
ТГХШХ-ИЙН ДАРГА Ө.МӨНХЧУЛУУН

БОЛОВСРУУЛСАН
ТГХШХ-ИЙН
МЭРГЭЖИЛТЭН Ц.ЦЭЦЭНЧИМЭГ